



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САНГИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/13/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжапрал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261628 Цахим хаяг: narangerelba@audit.gov.mn
Аудитор: Н.Баттөгөлдөр
Утас: 261885 Цахим хаяг: battuguldurn@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.ӨНӨРБАЯР ТАНАА

2022.03.25 № 07/704
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.ӨНӨРБАЯР ТАНАА**

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.


Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Я.САРАНСҮХ

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3.Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.7 Аудитын гол асуудал	9
3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	9
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
4. Аудитын илрүүлэлт	11
4.1 Албан шаардлага.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,801,600,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,801,600,000.00	-
413	Өглөг	6,801,600,000.00	-
4136	Бусад өглөг	6,801,600,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	6,801,600,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	(6,801,600,000.00)	-
51	Засгийн газрын хувь оролцоо	(6,801,600,000.00)	-
512	Хуримтлагдсан үр дүн	(6,801,600,000.00)	-
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,798,359,550.00)	(6,726,400,000.00)
51220	Тайлант үеийн үр дүн	(4,003,240,450.00)	6,726,400,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	52,295,306,150.00	63,893,008,399.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,700,900,000.00	56,715,400,000.00
Нийтлэг татварын бус орлого	45,700,900,000.00	56,715,400,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	45,700,900,000.00	56,715,400,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,700,900,000.00	56,715,400,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,594,406,150.00	7,177,608,399.00
Улсын төвлөрсөн төсвөөс	6,594,406,150.00	7,177,608,399.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,594,406,150.00	7,177,608,399.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	56,298,546,600.00	57,166,608,399.00
УРСГАЛ ЗАРДАЛ	56,298,546,600.00	57,166,608,399.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,593,061,410.00	7,177,496,339.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,593,061,410.00	7,177,496,339.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,593,061,410.00	7,177,496,339.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,705,485,190.00	49,989,112,060.00
Бусад урсгал шилжүүлэг	49,703,300,000.00	49,989,000,000.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,703,300,000.00	49,989,000,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,185,190.00	112,060.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,185,190.00	112,060.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(4,003,240,450.00)	6,726,400,000.00
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(4,003,240,450.00)	6,726,400,000.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	(2,798,359,550.00)	(2,798,359,550.00)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(2,798,359,550.00)	(2,798,359,550.00)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Тайлант үеийн үр дүн	-	-	(4,003,240,450.00)	(4,003,240,450.00)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(6,801,600,000.00)	(6,801,600,000.00)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	75,200,000.00	75,200,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(6,726,400,000.00)	(6,726,400,000.00)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	6,726,400,000.00	6,726,400,000.00
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	52,295,306,150.00	63,893,008,399.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,700,900,000.00	56,715,400,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	45,700,900,000.00	56,715,400,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,700,900,000.00	56,715,400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,700,900,000.00	56,715,400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,594,406,150.00	7,177,608,399.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,594,406,150.00	7,177,608,399.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,594,406,150.00	7,177,608,399.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	52,295,306,150.00	63,893,008,399.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,295,306,150.00	63,893,008,399.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,592,220,960.00	7,177,496,339.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,592,220,960.00	7,177,496,339.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,592,220,960.00	7,177,496,339.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,703,085,190.00	56,715,512,060.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,700,900,000.00	56,715,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,700,900,000.00	56,715,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,185,190.00	112,060.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,185,190.00	112,060.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,917,094,900.00	63,892,896,339.00	2,024,198,561.00	96.9
2	УРСГАЛ ЗАРДАЛ	65,917,094,900.00	63,892,896,339.00	2,024,198,561.00	96.9
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,169,542,900.00	7,177,496,339.00	992,046,561.00	87.9
4	Бараа үйлчилгээний бусад зардал	8,169,542,900.00	7,177,496,339.00	992,046,561.00	87.9
5	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,169,542,900.00	7,177,496,339.00	992,046,561.00	87.9
6	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,747,552,000.00	56,715,400,000.00	1,032,152,000.00	98.2
7	Бусад урсгал шилжүүлэг	57,747,552,000.00	56,715,400,000.00	1,032,152,000.00	98.2
8	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,747,552,000.00	56,715,400,000.00	1,032,152,000.00	98.2
9	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,917,094,900.00	63,892,896,339.00	2,024,198,561.00	96.9
10	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,169,542,900.00	7,177,496,339.00	992,046,561.00	87.9
11	Улсын төсвөөс санхүүжих	8,169,542,900.00	7,177,496,339.00	992,046,561.00	87.9
12	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	57,747,552,000.00	56,715,400,000.00	1,032,152,000.00	98.2
13	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,747,552,000.00	56,715,400,000.00	1,032,152,000.00	98.2
14	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	18,228.00	14,122.00	4,106.00	77.5
15	БАЙГУУЛЛАГЫН ТОО	42	32	10	76.2
16	Төсвөөс гадуур байгууллага	42	32	10	76.2
17	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	18186	14090	4096	77.5
18	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	18186	14090	4096	77.5
19	Хувийн МСҮТ	18186	14090	4096	77.5

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтыг батлагдсан маягтын дагуу хөтөлж байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын аудитор Н.Баттөгөлдөр, ахлах аудитор Б.Нарангэрэл нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Аудитын хоёрдугаар газрын менежер Ц.Хосжаргал, Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 03/553 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг ерөнхий боловсролын сургуулийг төгсөгчид болон ажилгүй залуучууд, иргэдэд богино хугацаанд нийгэм, хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай болгох замаар ажилгүйдэл, ядууралтай тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг дараах байдлаар хуваарилан зарцуулна” гэж заажээ. Үүнд:

- Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, түүнчлэн сурагчийн дотуур байрны нийт зардал;
- Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг;
- Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах зардал;
- Хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах зардал.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд дээд шатны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 56,298.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 562.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар өр төлбөр үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгаа	-	-	-
Нийт хөрөнгө	-	-	-
Өр төлбөр	6,801,600.0	-	(6,801,600.0)
Засгийн газрын оролцоо /эздийн өмч/	6,801,600.0	-	(6,801,600.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	-	-

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 11,597.7 төгрөгөөр буюу 22.1 хувиар өссөн нь 2021 онд суралцагчдын тоо нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 868.1 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн нь МСҮТ-д суралцагчдын тооноос шалтгаалан хувьсах зардал, суралцагсдад олгох тэтгэлэг нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон урсгал зардлыг 88,487.9 сая төгрөгөөр боловсруулж, дээд шатны захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 7,089.8 сая төгрөгөөр бууруулж, 81,398.1 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Төсвийн тодотголоор 65,917,094.9 мянган төгрөг болгож бууруулсан. Үүний 8,169,542.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 57,747,552.0 мянган төгрөгийг Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тодотголоор Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 65,917.1 сая төгрөгөөр тодотгож, 8,169.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 57,747.6 сая төгрөгийг Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,177.5 сая төгрөг, Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас 56,175.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зарлага цэвэр зээлийн дүн 63,892.9 сая төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь МСҮТ-д олгох хувьсах зардал 992.0 сая төгрөг, МСҮТ-д суралцагсдад сар бүр олгох тэтгэлэг 1,032.2 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Зарцуулагдаагүй үлдэгдэл 0.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71804	Мэргэжлийн боловсрол	65,917,094.9	63,892,896.3	2,024,198.6	96.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	8,169,542.9	7,177,496.3	992,046.6	87.8
1.2	81808	МСҮТ-д суралцагсдад сар бүр олгох тэтгэлэг	57,747,552.0	56,715,400.0	1,032,152.0	98.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Аудитын гол асуудал

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх, сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэн батлуулах шаардлагатай байна.

3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 151 мэдээлэл оруулахаас 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах албан шаардлага хүргүүлэх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэхдээ батлагдсан анхан шатны баримтын НХМаягт ТМ-3 маягтын дагуу хөтлөөгүй нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагатай тооцоо нийлэхдээ анхан шатны баримтыг батлагдсан маягтын дагуу хөтлөх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан зааврын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	2	-			90%
Зөвлөмж	1	-	1	-			90%
Нийт дүн	3	-	3	-			90%

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Албан шаардлага

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлэн батлуулах талаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасантай нийцээгүй, өмнөх оны аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах гэсэн санхүүгийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагаанд тайлант онд дээд шатны байгууллагаас хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ”, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.3.5-д “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс										
							Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлаг а тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
		Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:															
1	МБСДС	АХГ-2022/13/НА-СТА-ЗГТС	Тайлант онд ТЕЗ МБСДСангийн үйл ажиллагаанд Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын шалтгалт оруулаагүй, сангийн үйл ажиллагаанд тавигдах хяналт сул байна.	Хуульд заасны дагуу тусгай сангийн үйл ажиллагааг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитад хамруулах	1						1	-					
2	МБСДС	АХГ-2022/13/НА-СТА-ЗГТС	Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлэн батлуулах талаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангалтгүй байна.	Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлэн батлуулах	1						1	-					
Дүн					2	-					2	-					
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:																	
1	МБСДС	АХГ-2022/13/НА-СТА-ЗГТС	Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэхдээ батлагдсан анхан шатны баримтын НХМаягт ТМ-3 маягтын дагуу хөтлөөгүй	Харилцагч байгууллагатай тооцоо нийлэхдээ анхан шатны баримтыг батлагдсан	1										1	-	

				маягтын дагуу хөтлөх зөвлөм өгөх.												
2	МБСДС	АХГ- 2022/13/НА- СТА-3ГТС	Шилэн дансны мэдээллэвэл зохих 151 мэдээлэл байршуулахаас хугацаанд 138, хугацаа хоцроосон 13 мэдээлэл байна.	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах	1						1	-				
Дүн					2						1				1	
Нийт дүн					4						3				1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 772/А0170016
АХГ-2022/13/НА-СТА-ЗГТС
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагаанд тайлант онд дээд шатны байгууллагаас хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийгээгүй байна.


Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 "Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ", Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.3.5 "Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуульд заасны дагуу тусгай сангийн үйл ажиллагааг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитад хамруулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Ерөнхий нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Н.БАТТӨГӨЛДӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 743 / А0140016

Улаанбаатар хот

АХГ-2022/13/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 151 мэдээлэл оруулахаас 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Ерөнхий нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Н.БАТТӨГӨЛДӨР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\chig_khereg\Alban_Shaardlaga\2022\0325 Auditin 2 Газар-428.Docx

0001021289



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 741/А0140016

Улаанбаатар хот

АХГ-2022/13/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлэн батлуулах талаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлэн батлуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, ерөнхий нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Н.БАТТӨГӨЛДӨР



This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for consistent letter formation. There is no text or other markings on the page.

[illegible]